**Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр**

**Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар**

**2023 оны XI сар**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг | 3. Экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ | 2021 - 2024 | ЖДҮХСан - 99,4 сая.төгрөг<br>ХХСан - 30,4 сая.төгрөг. | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 50-аас доошгүй ААН-д хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын дэмжлэг үзүүлнэ. | Баянжаргалан сумын малчин Б.Цолмонбаатар, Д.Байгальмаа нар Холбоо Бумбан ХХК-г байгуулан Жижиг Дунд Үйлдвэрийг Хөгжүүлэх Сангаас 99,400,000 төгрөгийн зээл авч эрчимжсэн мал, аж ахуйн чиглэлээр буюу Цэвэр 100 хувийн хээлтүүлэгч азарга худалдан авч үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр 2 ажлын байр бий болсон байна.<br>Дэлгэрхангай сумын малчин Б.Хосбат нь Хоршоо Хөгжүүлэх Сангаас 30,4 сая.төгрөгийн зээл авч газын баллоны саваар үйлдвэрлэсэн зуухаа патентжуулан зах зээлд борлуулж байна. Энэ онд 53 ширхэг зуух үйлдвэрлэн 21.2 сая.төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 2 | 3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. | 2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | Шинэ хөдөө төсөл - 79,9 сая.төгрөг<br>Хувийн хэвшил- 2,5 тэрбум.төгрөг | Ээрэх, нэхэх, сүлжих хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлснээр 100 орчим ажлын байр бий болсон байна. | Их онь ХХК нь ноос угаах үйлдвэрийг өргөтгөж тоног төхөөрөмжөө шинэчлэн ноос угааж самнах үйл ажиллагааг эрхэлж 1500 тн ноос угааж эхлээд байна. Түр 100 ажлын байр бий болгосон,<br>Шинэ хөдөө төслийн хүрээнд Эрдэнэдалай суманд 79,9 сая.төгрөгийн үнэ бүхий арьс, шир элдэх жижиг үйлдвэрийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. | 100 |
| 3 | 3.7.4. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурины тодорхойлж, агаарын тээвэр, авто | 5. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна. | 2020 - 2024 | 146,8 сая | 18 сум | Цагаандэлгэр сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Сонголт дизайн” ХХК-тай 98,8 сая, Эрдэнэдалай сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Сонголт дизайн” ХХК-тай 98,0 сая, Дэрэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг “Ланд овнер” ХХК-тай 94,6 сая төгрөгөөр тус тус байгуулж, Эрдэнэдалай, Цагаандэлгэр сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хүлээн аваад байна.<br>Ингэснээр Дундговь аймгийн нийт 15 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй боллоо. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зам, төмөр замын сүлжээнд холбоно. | | | | | | |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 17 | 6.2.13. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Түүхий эдийн нөөцөд тулгуурлан орон нутгийн онцлогт тохирсон ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 2021 - 2024 | ЖДҮХСан - 422,64 сая.төгрөг | Ажлын байр нэмэгдсэн байна. | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас мах махан бүтээгдэхүүн боловсруулах, борц хийх чиглэлээр Сайхан-Овоо сумын Эрхэст Ундарга ХХК, Сайнцагаан сумын Цутгуурч ХХК, Дэлгэр номт Ундраа ХХК нар нийт 422,640,000 төгрөгний хөнгөлөлттэй зээлийг авсан. Ингэснээр 7 ажлын байр хадгалагдаж 7 ажлын байр шинээр бий болсон байна. | 100 |
| 18 | 6.2.14.. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай орчныг бий болгоно. | 2. Хөдөө орон нутгийн жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийн худалдаа, борлуулалтыг дэмжих дэд бүтцийг бий болгон бизнес эрхлэх нэн таатай | 2021 - 2024 | ОНТ-542,6 сая.төгрөг | Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ. | Түрээсийн өндөр төлбөр төлдөг иргэн, ААнэгжүүдийг урсгал зардалаа төлдөг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлсэн.<br>Бизнес хөгжлийн төвд 4 аж ахуй нэгж, 16 бизнес эрхлэгч нийт 20 хүнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулж, үйл ажиллагааг тогтвортой явуулах, бизнесийг нь өргөжүүлэх зорилгоор шинээр нээгдсэн бизнес хөгжлийн төвд бойжуулж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орчныг бий болгоно. | | | | | |
| | | | | | | | 100 |